

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 09 дүгээр сарын 10

Сайншанд хот

Д/д	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
<b>Албан хаагчдыг чадавхижуулах сургалтын арга хэлбэрийг өргөжүүлэх</b>			
1	Төрийн албан хаагчдын албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, чадвар, арга зүйг өргөн хүрээнд эзэмшүүлэх боломж нөхцлийг хангана	Богино хугацааны	Тайлант хугацаанд богино хугацааны сургалтанд хамрагдах хүсэлт ирээгүй байна.
2		Дунд хугацааны	Удирдлагыг академийн дунд хугацааны сургалтанд Замын-Үүд сумын улсын бүртгэгч Б.Мөнх-Учрал хамрагдсан.
3		Албан тушаалын мэргэшүүлэх	Тус хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Г.Батсайхан, Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг нар нь Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах тухай хүсэлтийг УБЕГ-ын Эрх зүйн сургалтын хэлтэст хүргүүлсэн.
5	Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв шинээр авсан, ахиулсан байдал		УБЕГ-ын даргын 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн Б/458 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон 1, зэрэг дэвийг 8 албан хаагчид ахиулан олгосон байна.
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлнэ	Цахим систем, компьютер техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад хөрөнгө оруулалт	Аймгийн Засаг даргын 2024 оны "Дэмжлэг үзүүлэх тухай" А/406 тоот захирамжаар тус хэлтэст 19,832,050 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
7	Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлнэ	Түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдсан албан хаагчид	Тус хэлтэс нь 2025 оныг "Төрийн бүтээмж, нийгмийн баталгааг хэрэгжүүлэх жил"-ийн хүрээнд хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Энержи прагон ХХК-тай уулзалт хийж тус хэлтсийн албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр байр захиалах, мөн

			аймгийн Засаг даргын орлогч Г.Марттай уулзан албан хаагчдыг түрээсийн орон сууцанд оруулах талаар саналыг тус тус хүргүүлсэн
8		Хоол унааны нөхөх төлбөрт зарцуулсан хөрөнгө	УБЕГ-ын даргын 2024 оны А/500 тушаалаар хоол унааны нөхөх төлбөрийн зардлыг өдрийн 25 000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.
9		Хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгосон тусламж, дэмжлэг, хамрагдсан албан хаагчид	Улсын бүртгэлийн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу ар гэрт гачигдал тохиолдсон, албан хаагч, гэр бүлд нь нийт 4,380,000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна
10		Шинээр болон шинэчлэн баталсан журам	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаарын тушаалаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
11	Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд агентлагийн хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	Улирлын мөнгөн урамшуулалд хамрагдсан албан хаагчид	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай журам"-ын 1.2.2, 2.2, 2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Журам шинэчилэн батлах тухай" 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн албан хаагчдад 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр мөнгөн урамшуулал олгосон.
12		Орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулалд хамрагдсан албан хаагч, олгосон санхүүжилт	Дорноговь аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/420 дугаар захирамжаар орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдад сар бүр 20 хувийн нэмэгдэл болох мөнгөн урамшуулал олгосон.